

TAFE NSW ХӨТӨЛБӨРӨӨР АНГЛИ ХЭЛНИЙ ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЭЭРЭЙ

СУДАЛ. ЛАВЛА. БҮРТГҮҮЛ.
TAFENSW.EDU.AU/INTERNATIONAL

NSW GOVERNMENT | TAFE NSW
INTERNATIONAL

TAFE NSW ХӨТӨЛБӨРӨӨР АНГЛИ ХЭЛ СУРААРАЙ

Одоо долоо хоногийн 250 австрали долларoор манай онлайн хөтөлбөрүүдэд эх орноосоо элсэн суралцах боломжтой боллоо*

Дэлхийн өнцөг булан бүрээс холбогдох оюутнуудын хамт англи хэлний сургалтад хамрагдаж дүүргээрэй

Австралиас өөр улс орнуудад байгаа оюутнууд TAFE NSW англи хэлний сургалтын хөтөлбөрт элсэн суралцах боломжтой. Англи хэлээр унших, бичих, ярих, сонсох чадвараа дээшлүүлж, ирээдүйн сургууль, мөрөөдлийн ажил, амьдралдаа бэлтгээрэй.

TAFE NSW-Д МЭРГЭЖЛИЙН ЭСВЭЛ ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЗЭРГИЙН ХӨТӨЛБӨРТ ЭЛСЭН СУРАЛЦАХАД БЭЛТГЭЭРЭЙ.

TAFE NSW-д англи хэл сурах шалтгаан

- Нарийн мэргэшсэн, туршлагатай багш нар оюутнуудтайгаа сайн тулж ажилладаг
- Даваагаас баасан гараг хүртэл өдөр бүр 4 цаг хичээллэдэг (Ньюкаслын хувьд даваагаас пүрэв хүртэл)
- Хөтөлбөр тус бүр долоо хоногт 20 цаг хичээллэж, биечлэн суралцах хөтөлбөртэй ижил үр дүнтэй сургадаг
- Office 365 программ хангамж, үүний дотор Microsoft Teams, Outlook, OneDrive, Word, Excel, Powerpoint программуудыг ашиглах боломжтой
- Мэдээллийн технологийн алба бүх оюутанд дэмжлэг үзүүлж ажиллана

МЭРГЭЖЛИЙН ОНЛАЙН ТУСЛАМЖ

Мэдээллийн технологийн албаны тусламжтай бид оюутнуудаа хамгийн өндөр чанарын суралцах орчноор хангаж, англи хэлний зорилгодоо хүрэх боломжийг бүрдүүлдэг. TAFE NSW-н онлайн сургалтын орчинд багш, оюутнууд шууд хамтран ажиллах боломжтой юм. Манай оюутнууд эх орноосоо бидэнтэй холбогдож суралцах боломжтой болсон нь маш таатай хэрэг бөгөөд бид оюутнуудтайгаа тулж ажиллан, англи хэлний чадвараа дээшлүүлэхэд нь тусалж чадна гэдэгтээ итгэлтэй байна.

Австралийн гадна байрлах оюутнуудын хувьд. Мөн захиргааны зардалд зориулан 150 австрали долларын өргөдлийн хураамж авах болно. Энэ үнэ 2021 оны 12-р сарын 31 хүртэл хүчинтэй.

© TAFE NSW 2020 Нийтлэх үед залруулах (2020 оны 11-р сар). RTO 90003 | CRICOS 00591E | HEP PRV12049

NSW GOVERNMENT | TAFE NSW INTERNATIONAL

TAFE NSW АНГЛИ ХЭЛНИЙ ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ СУДАЛНА УУ

Ерөнхий англи хэлний хөтөлбөр (CRICOS #049258C)

ЭНЭ ХӨТӨЛБӨР ЯМАР ЗОРИЛГОТОЙ ВЭ?	ХӨТӨЛБӨРИЙН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА:	ЖИЧ:
Аялах, суралцах зорилгоор англи хэлний мэдлэгийн түвшнээ дээшлүүлэх эсвэл дэлхий даяар англи хэлтнүүдтэй харилцах. Энэ хөтөлбөр танд дүрмийн мэдлэг, ярих, сонсох, унших, бичих чадвараа хөгжүүлэхэд тусална. Та анхан шатнаас ахисан шат хүртэл аль ч шатнаас эхэлж болох бөгөөд өөрийн хэрэгцээний дагуу аль ч шатанд хөтөлбөрийг дуусгах боломжтой.	2 - 50 долоо хоног (долоо хоногт 20 цаг)	Та дундаас дээш шатыг амжилттай дүүргэвэл элсэхэд IELTS-ийн 5.5 онооны шаардлага тавьдаг TAFE NSW-ийн хөтөлбөрүүдэд шууд орох боломжтой болно.

Их дээд сургуулийн англи хэл (CRICOS #0101064)

ЭНЭ ХӨТӨЛБӨР ЯМАР ЗОРИЛГОТОЙ ВЭ?	ХӨТӨЛБӨРИЙН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА:	ЖИЧ:
Энэ хөтөлбөр таны англи хэлний мэдлэгийн түвшнийг дээшлүүлж, Австралид эрдмийн болон дээд боловсролын сургалтын хөтөлбөрт амжилттай хамрагдах арга туршлагыг сайжруулах болно. Тус хөтөлбөр нь таны хувьд дараачийн шатны сургалтад шаардагдах түвшний мэдлэгтэй болохоороо дуусгаж болох уян хатан сонголттой.	5 - 20 долоо хоног (долоо хоногт 20 цаг)	Энэ хөтөлбөрт элсэхэд IELTS-ийн 5.5 оноо буюу түүнтэй дүйцэхүйц шаардлага тавигдана. TAFE NSW Англи хэлний төвд дундаас дээш шатны (CEFR B2) сургалтыг амжилттай дүүргэсэн оюутнууд Их дээд сургуулийн англи хэлний хөтөлбөрт элсэнэ.

© TAFE NSW 2020 Нийтлэх үед залруулах (2020 оны 11-р сар). RTO 90003 | CRICOS 00591E | HEP PRV12049

NSW GOVERNMENT | TAFE NSW INTERNATIONAL

TAFE NSW АНГЛИ ХЭЛНИЙ ТӨВИЙН ТУХАЙ ПРАКТИК МЭДЭЭЛЭЛ

Манай англи хэлний хөтөлбөрүүд уян хатан сонголтуудыг санал болгодог бөгөөд жилийн 50 долоо хоногийн даваа гараг бүрд эхэлдэг. Сургалтын хамгийн сайн үр дүн холимог сургалтын аргатай холбоотой байдаг учраас англи хэлний сургалтын ердийн долоо хоног унших, бичих, сонсох чадварын хичээл, бүлгийн ажил, хэлэлцүүлэг, харилцан ярианаас бүрдэнэ. TAFE NSW дээр янз бүрийн хичээлээс бүрдэх долоо хоногийн 20 цагийн сургалтаар та англи хэлийг хялбар бөгөөд түргэн сурах боломжтой.

ДАВАА	МЯГМАР	ЛХАГВА	ПҮРЭВ	БААСАН
Унших чадвар	Цогц чадвар	Компьютер	Сонсох чадвар	Бичих чадвар
Сонсох чадвар	Унших чадвар	Бичих чадвар	Унших чадвар	Дуудлага
Хэлэлцүүлэг	Бичих чадвар	Цогц чадвар	Ярих чадвар	Харилцан яриа

Жич: зарим газар хичээл даваагаас пүрэв хүртэл орно. Хичээл ердийн үед 9:00 цагаас 13:30 хүртэл орох бөгөөд дундаа 30 минутын нэг завсарлагатай. Мягмар, пүрэв гарагуудад 14:00-15:00 цагт нэмэлт ганцаарчилсан хичээл авч болно. Цагийн хуваарийг зөвхөн жишээ болгон үзүүлсэн бөгөөд өөрчлөгдөж болно.

TAFE NSW хөтөлбөрийн багш нар

TAFE NSW хөтөлбөрт мэргэжлээрээ дор хаяж таван жил ажилласан туршлагатай, салбартаа нэр хүндтэй хэлний мэргэжилтнүүд багшилдаг. Манай багш нар оюутнууддаа чин сэтгэлээсээ анхаарал тавьж, танд болон таны ирээдүйн төлөө цаг заваа зориулж ажилладаг. Тиймээс ч тэд олон улсад сургалтын чанараараа тэргүүлдэг нэр хүндтэй.

TAFE NSW дээр танд мэргэжилтнүүд багшлах болно. Манай багш нар нарийн мэргэшсэн, тэвчээртэй, эелдэг хүмүүс бөгөөд танд англи хэлээ сайжруулж, карьерынхаа зорилгод хүрэхэд тань туслах чин эрмэлзэлтэй билээ. Манай сургалтдаа баримталдаг харилцааны аргачлал оюутнуудыг анги танхимд сурсан хэлээ бодит амьдралд хэрэглэж, харилцахад түлхэц өгч урамшуулдаг.

© TAFE NSW 2020 Нийтлэх үед залруулах (2020 оны 11-р сар). RTO 90003 | CRICOS 00591E | HEP PRV12049

NSW GOVERNMENT | TAFE NSW INTERNATIONAL

Цааш суралцах зам

TAFE NSW танд сонгосон мэргэжил эсвэл дээд боловсролын чиглэлээрээ элсэн суралцах англи хэлний шаардлагыг хангахад тусална.

TAFE NSW англи хэлний хөтөлбөрт суралцсан тохиолдолд танд TAFE NSW-ийн гадаад оюутнуудад санал болгодог сургалтын аль ч хөтөлбөрт баталгаатай элсэн орох боломжийг санал болгоно. Үүнд мэргэжлийн (сертификат, ахисан түвшний диплом)* болон бакалаврын зэргийн сургалтын хөтөлбөрүүд багтана

TAFE NSW-ийн Их дээд сургуулийн англи хэлний хөтөлбөрийг Австралийн дээд боловсролын хэд хэдэн байгууллага хүлээн зөвшөөрч, өөрсдийн эрдмийн зэргийн сургалтын хөтөлбөрт элсэх англи хэлний шаардлагыг хангасанд тооцдог.

Надад хичээлдээ ирэхэд үргэлж сайхан санагддаг. Манай анги найрсаг багш нар болон гадаад оюутнуудтай тул англи хэлний хичээлд суухад надад үнэхээр таатай байдаг. Багш нар маань бидний англи хэлний чадварыг дээшлүүлэхийн тулд илүү таатай орчныг бүрдүүлэх талаар чармайн ажилладаг. Хэрэв оюутнууд ямар нэг үгний утгыг ойлгохгүй байвал багш нар тэр үгийг интернэтээс хайж, өөрсдийн дэлгэцийг бидэнтэй хуваалцаж зургаар дүрслэн харуулдаг. Ингэснээр оюутнуудад тухайн үгийг ойлгоход маш хялбар дөхөм болдог бөгөөд энэ нь онлайн хичээлийн нэг давуу тал гэж би бодож байна.

Вакана Хироно, Япон

ТАТГАЛЗАЛ

Энэ товхимолд орсон мэдээллийг хэвлэгдэх үеийн (2020 оны 11-р сар) байдлаар аль болох үнэн зөв байлгахыг хичээсэн болно. Нэмэлт мэдээллийг интернэтээр tafensw.edu.au/international/study/courses/english хаягаас олж авах боломжтой. ^IELTS эсвэл OET шалгалтын оноо шаарддаг Сувилахуйн ухааны дипломоос бусад хөтөлбөр.

© TAFE NSW 2020 Нийтлэх үед залруулах (2020 оны 11-р сар). RTO 90003 | CRICOS 00591E | HEP PRV12049

NSW GOVERNMENT | TAFE NSW INTERNATIONAL

Алтимо, Мидоубэнк, Кингсклифф, Воллонгон, Ньюкасл

Алтимо

Ньюкасл

Ньюкасл

Мидоубэнк	telc@tafensw.edu.au
Ньюкасл	hunter.elc@tafensw.edu.au
Алтимо	sit.englishcentre@tafensw.edu.au
Воллонгон	inter.illawarra@tafensw.edu.au
Кингсклифф	nci.international@tafensw.edu.au

СУДАЛ. ЛАВЛА. БҮРТГҮҮЛ.
TAFENSW.EDU.AU/INTERNATIONAL

RTO 90003 | CRICOS 00591E | HEP PRV12049